

ДАЯАРШИЛ БА БУУРАЙ ХӨГЖИЛТЭЙ ОРНУУДЫН ЭРХ АШИГ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

*МУИС, ОУХС-ийн тэргүүлэх
профессор, доктор (Ph.D) Д.Цолмон*

Эдүгээ даяаршлын үйл явц амьдралын бүхий л салбарыг эрчимтэй хамарч байгааг, ялангуяа худалдаа, эдийн засаг, улс төр, соёл, холбоо, мэдээллийн салбарт болж буй харилцан хамаарал эрчимжиж байгаад эргэлзэх зүйлгүй. Эдүгээ орчин үеийн олон улсын харилцаа даяаршлын үрээр шинэчлэгдэн хөгжиж байна. Энэ нь хүйтэн дайны дараахи үеийг бүхлээр нь тодорхойлох болов. Дэлхийн олон улс өөрийн хөгжил, ирээдүйг даяаршилтай холбон тайлбарлаж байгаа бөгөөд эл үзэгдэл ОУХ-ны нэг чухал чиг хандлага, дэлхийн түгээмэл асуудал болсныг судлаачид тэмдэглэж байна.

Гэхдээ даяаршлыг хүчтэй дэмжин сурталчилж буй нэг хэсэг (АНУ-ын судлаачид), түүнийг улс үндэстний эрх ашиг, онцлогтой уялдуулан тайлбарлаж буй хэсэг (ОХУ), Америкийн жанжлалын бодлоготой холбон үзэж буй хэсэг (Хятад), өмнөд, умардын зөрчил буюу техник технологи өндөр хөгжсөн орнууд хожиж, буурай улс орнуудын хөгжлийн зааг ялгаа улам гүнзгийрч байгаад ихэд сэрэмжилж хандаж буй хэсэг гэж ангилж үзэж болох юм. Энэ нь даяаршлын үйл явцад улс гүрнүүдийн судлаачдын хандах хандлага өөр өөр байгааг гэрчилнэ.

Манайд даяаршлын мөн чанарыг олон улсын харилцааны салбарт тодорхой бусад салбарын мэргэжилтнүүд голлон судлах нь чухал бөгөөд хэн дуртай нь өөрийгөө дөвийлгөх үүднээс ямар ч шинжлэх ухааны үндэслэлгүй, хүмүүсийн бичсэнийг найруулан хувийн сонин хэвлэлдээ нийтлэх хандлага гарсаар байна. Энэ бол олон түмэнд цэгцтэй ойлголт өгөхөд саад болж байгаа сөрөг үзэгдэл, бас зохиогчийн эрхийг зөрчиж буй гаж явдал мөн. Энэ нь их мэдэгчдийн гэм биш зан болсныг дурдахад илүүдэхгүй.

Зарим судлаачид даяаршлыг гол төлөв эдийн засгийн утгаар нь буюу дэлхийн капиталын¹ үүднээс тайлбарлаж байхад нөгөө нэг хэсэг нь олон улсын байгууллагууд, дэглэмүүд² гэдэг утгаар ойлгож байна. Хүн ам, хүрээлэн буй орчин, соёлын нөлөөний урсгал, хөдөлгөөнд анхаарал хандуулж буй эрдэмтэд ч байна.³ Бас "иргэний глобаль нийгмийг" үүсгэх

¹ Richard Little, *International Relations and the Triumph of Capitalism*, in Booth, K. & Smith, S. (eds) 1995: *International Relations Theory*, The Pennsylvania State University Press, pp62-89.

² John Gerard Ruggie, *International Transformations: Essays on Institutional Change in the World Polity*, Routledge, London, USA & Canada, 1998.

³ Sassen, S. 1991. *The Informal Economy. I: Dual City: Restructuring New York*, ed. J.H. Mollenkopf and M. Castells, 79-99. New York: Russell Sage Foundation.

хил хальсан, үндэстэн дамнасан сүлжээ буй болж байгааг тэмдэглэж байна.⁴

Дээрх үзэл баримтлалууд нь хоорондоо уялдаатай нэг том үзэгдлийг янз бүрийн өнцгөөс харж тодорхойлох оролдлого бөгөөд уг асуудалд иж бүрэн хандах учиртай гэж үзнэ.

Алисон Бриск (Alison Brysk 1999)-ийн тодорхойлсноор даяаршил гэдэг бол "орон зай, үндэсний шинж төрхийн мөн чанар, ач холбогдлыг өөрчилж дэлхийг нэг айл болгож буй үйл явдлууд юм". Хэдийчинээ дэлхий даяаршина, төдийчинээ харилцан хамаарал, холбоо нягт сүлжилдсэн "космополитан" ертөнц буй болно гэж тэрээр томъёолжээ.

Даяаршлын жинхэнэ мөн чанарын хувьд судалж үзэхэд юуны түрүүнд өөрчлөлт, шинэчлэлт хүн төрөлхтний хөгжлийн угийн шинж чанар гэдгийг бодолцох хэрэгтэй.

Даяаршил гэдэг нь нэгийн дутууг нөгөөгөөс нөхөх харилцан хамаарал гүнзгийрэн хурдасч буй цогцолбор дэлхий дахиныг хамарсан эртнээс улбаатай үйл явц юм.

Австралийн Мельбурны бизнесийн сургуулийн эдийн засагч Дэвид Хэндерсон даяаршлыг өөр хоорондоо холбоотой таван зүйлд хувааж авч үзсэн байна. Үүнд:

1.Пүүс, компаниуд ирээдүйгээ бодож төлөвлөх, хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулахдаа дэлхийг улам бүр нэг зах зээл, боломж хэмээн үзэх хандлага хүчтэй болсон;

2.Интернет сүлжээ өргөсч, олон улсын харилцаа холбоо хялбар, хямд төсөр болсон;

3.Улс орнуудын эдийн засаг улам бүр интеграцчлагдаж албан ёсны бодлого, худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлахад чиглэж интеграцийн үйл явцыг нэн ихээр хурдасгаж байна;

4.Улс орнуудын хил хязгаараас давсан асуудлуудын ач холбогдол улам бүр нэмэгдэж, түүнийг олон улсын түвшинд хамтран шийдэх хандлага хүчтэй болсон;

5.Дэлхий нэгдмэл нэг гэр орон, нийтлэг дэг журам, гольдрил, жишиг, үйл ажиллагаа зэрэгт үндэслэгдсэн хэмээжээ.

Улс хоорондын харилцаанд ч даяаршлын агуулга үзэл санаа хэрэгжиж буйг НҮБ-ын хүрээнд болсон Дэлхийн энх тайвны Мянганы дээд хэмжээний чуулга (2000.IX) бусад олон үйл явдал гэрчилж байна. Эндээс үзэхэд даяаршил нь бүх дэлхийг хамарсан үйл явц болохын хувьд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт илэрч байна. Улсуудын хоорондын харилцан хамаарал, юуны түрүүнд эдийн засаг, санхүү, шинжлэх ухаан, боловсрол, байгаль хамгаалах салбарт түлхүү илэрч байна. Өнөөдөр аливаа улсын эдийн засгийг даяаршилгүйгээр төсөөлөхийн аргагүй болсон үе юм. Тийм ч учраас ихэнх хүмүүс эл үйл явцыг шинжлэх ухаан,

⁴ Lipschutz, R. 1996. Global Civil Society and Global Environmental Governance. New York: SUNY Press; Wapner, P. 1995. Politics Beyond the State Environmental Activism and World Politics. World Politics, 47 (3, April 1995): 311-40

боловсрол, мэдээлэл, технологи, эдийн засгийн хэмжүүрээр дүгнэх хандлагатай байна.

Дэлхийн эдийн засгийн интеграцчлал XX зууны хоёрдугаар хагасаас хүчтэй өрнөж нийтлэг зах зээлийн үндэс тавигдаж, үндэсний эдийн засаг нөгөөтэйгээ улам бүр ойртох болов. Эдүгээ интеграцчилагдсан байгууллагуудын тоо дэлхий хэмжээнд өссөөр байна. Эдгээр нь эдийн засгийн хийгээд улс төрийн бодит суурь баазтай болсон ажээ. Үүний жишээнд Европын Холбоо, АСЕАН, НАФТА-г нэрлэж болно.

XX зууны 2-р хагасаас эхлэн соёлын даяаршил дэлхий дахиныг хамрах болов. Радио, зурагт, мэдээлэл холбоо, тухайлбал, интернет, сателлит болон дижитал (тоон) технологи зэрэг нь харилцаа холбоог цаг хугацааны хамаарлаас чөлөөлсөн эерэг талтай бөгөөд үүний зэрэгцээгээр хүний ёс суртахуун, сэтгэл санаа, үндэсний соёлд эерэг, сөрөг үр дагавартай үзэгдэл улам бүр газар авчээ.

Манай умард их хөршийн судлаачид даяаршлыг үндэсний эрх ашиг, дэлхий дахинд ОХУ-ын байр суурийн бэхжилт, геополитиктой холбон тайлбарлаж байна. ОХУ-ын судлаач Л.Н.Клепацкий даяаршлыг "Дэлхийн бодлогын тулгамдсан бэрхшээл болж байна"⁵ гэсэн бол томоохон судлаач, улс төрч Е.Примаков даяаршлыг хэд хэдэн талаас нь тайлбарлаад энэ бол урт удаан хугацааны үйл явц болохыг хүлээн зөвшөөрч, даяаршил нь үндэсний засгийн газруудын үүрэг ролийг саармагжуулах боловч үндэсний тусгаар тогтнолын асуудал бат бэх байх ёстой гэсэн санааг гаргаад АНУ дэлхийн эдийн засагт гагцаар ноёрхож чадахгүй. Хэт их гүрэн гэсэн ойлголт хуучирсан тухай мөн ОХУ, Хятад, Энэтхэг өөрсдийн ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, техник технологийн аргаар аюулгүй байдлаа хамгаалах зэрэг гадаад улс төрийн бодлогыг илэрхийлсэн байна.

"Нью-Йорк Таймс" сонины сурвалжлагч Томас Фрийдмэн⁶ даяаршлыг хамгийн сайн талаас нь харуулан хамгаалж байна. Тэрээр даяаршлын үед "хүчтэй нь хүчгүйгээ" гэдэг зарчмыг "хурдан нь удаанаа" гэсэн зарчмаар солигдсоныг тэмдэглээд даяаршлаас тусгаарлах нь улс оронд хохирол учруулах юм. Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн хувьд улс орнууд эл үйл явцаас ихийг хожиж байгаа гэжээ.

Харин даяаршлын сөрөг үр дагавруудыг анти-глобалистууд шүүмжилсээр байна. Тэд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ), Дэлхийн эдийн засгийн форум (Давос) зэргийн хурлууд, Америкийн улсуудын Чөлөөт худалдааны талаар Куебек хотноо хуралдсан дээд хэмжээний уулзалтын үеэр хотын гудамжинд даяаршил, чөлөөт худалдаа, үндэстэн дамнасан корпорациудыг эсэргүүцсэн жагсаал, цуглаан хийж замбараагүй байдал үүсгэн эд хөрөнгийн хохирол учруулж байв. Мөн 2001 оны 5 дугаар сард анти-глобалистууд Лондон хотын гудамжинд бас л үймээн дэгдээсэн юм.

⁵ Е.Примаков М.Ж.И. "Россия и международные отношения в условиях глобализации" №3 2001

⁶ Friedman, T. 2nd ed., LexusandOliveTree, NY: Anchor Books. 2000

Анти-глобалистууд даяаршлын гол институци болсон ДХБ нь баян, хөгжилтэй орнуудаас хөгжиж буй буурай орнуудад тулгах нөхцөл, дүрэм, журмыг биелүүлдэг гар хөл юм гэж үзэж байна. Худалдаа, ашиг хонжооны сонирхол нь хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлуудын дээгүүр тавигддаг, ДХБ улс орнуудын ажлын байрыг үгүй болгож, ядуурлыг улам лавшруулж жижиг буурай орнуудыг хохироож байна хэмээн эсэргүүцдэг ажээ.

Даяаршил засгийн газрын үүрэг ролийг саармагжуулдаг, ирээдүйд улс үндэстэн нэгдэнэ гэж хүний бичсэнийг хуулбарлан популист маягаар сүржигнэлгүйгээр үндэсний аюулгүй байдлаа яаж хамгаалах талаар цэгцтэй бодлого, нэгдмэл үйл ажиллагаа явуулах шаардлагатай байгаа юм.

Даяаршил хэмээх худалдаа, эдийн засаг, соёлын харилцаагаар дамжсан эртний үзэгдэл эдүгээ хүчээ авч байна. Үүнтэй уялдан юуг зөнгөөр нь орхих, юунд төр, засаг оролцох талаар ялгавартай авч үзмээр санагддаг.

Эдийн засгийн тэргүүлэх салбар, хэрэглээний зах зээл, үнийн бодлогыг монголчууд өөрсдөө тодорхойлж байна уу. Үнэндээ бид чинь хямд ажиллах хүчтэй, түүхий эдийн хавсрага орон хэвээрээ л байна. Энэ нь "шилжилтийн буруу" бишээ.

Мэргэжил боловсролтой залуус, өнгө зүс сайтай охид харьд яваад эргэж ирэх нь ховордов. Энэ шилжилтийн буруу юу? Гэмт хэрэг газар авч, архиндаа живж хуульт ёс үгүйлэгдэх болов. Энэ шилжилтийн буруу юу?

Бага буурай орнуудаас хөгжилтэй, чадавхитай орнууд илүү хөгжиж хөгжлийн зааг ялгаа улам гүнзгийрсээр байна. Энэ тухай Колумбын Гадаад худалдааны сайд Марта Рамирес де Ринкон хөгжиж буй орнууд хөгжингүй орнуудын адил худалдааны либералчлалаас хожихгүй байна гэсэн нь үндэстэй дүгнэлт мөн.

Даяаршлын цаана буурай хөгжилтэй орнуудын хувьд тодорхой эрсдэл бий. Судлаач Д.Баярхүү Дели хотноо хэвлүүлсэн товхимолдоо: даяаршлыг дэлхийн шинэ журам тогтож буй өнөөгийн нөхцөлтэй уялдуулан авч үзээд хөгжиж буй нэлээд улс орон, ялангуяа эдийн засгийн хувьд буурай хөгжилтэй орнуудад таатай боломжийн зэрэгцээ ихээхэн эрсдэл, бэрхшээл авчрах магадлалтай болохыг зөв зүйтэй авч үзсэн байна.⁷

Даяаршил улс орнуудын оршин тогтнох, иргэдийн эрх ашиг, аюулгүй байдал, эдийн засаг, мэдээлэл, соёл иргэншлийн болон удмын сангийн, экологийн аюулгүй байдалд зайлшгүй нөлөөлнө.

Үүнтэй холбогдуулан, хөрш орнууд даяаршилд хэрхэн хандаж, ямар алхам, арга хэмжээ авч буйг судалж үзэх нь манайх шиг өвөрмөц, хэврэг хараат эдийн засагтай улсын судлаачдын нэн түрүүнд хийх ажил гэж бодно. Бас их гүрнүүдийн тухайн асуудлаархи байр суурийг харгалзан үзэж байх нь чухал. Үнэндээ манай хоёр хөрш, Энэтхэг зэрэг томоохон улсууд даяаршлыг төдийлөн дөвийлгэж сурталчлахгүй байна.

⁷ The Challenge of Globalisation and the Shaping of New World Order. N.D. 2000. P.20

Бид өрсөлдөх чадвараа дээшлүүлнэ гэж ярьж бичиж байна. Тэгвэл юугаараа, яаж өрсөлдөж даяаршлын үр шимээс яаж хүртэх талаар нэгдмэл ойлголт үйл ажиллагаа учир дутагдалтай л байх шиг санагддаг.

Даяаршил бол жам ёсны түүхэн үйл явц юм. Түүнд орох, орохгүй гэдэг асуудал бол утгагүй юм. Харин хэрхэн тэсч үлдэх, яаж хожиж гарч ирэх зэрэг асуудал бол хамгийн чухал гэж үзнэ.

Улс орны хөгжил, аж ахуйн удирдлага аяндаа зах зээлийн жамаар зохицуулагдана. Төрийн оролцоо ихсэх тусам хямрал буй болдог гэж үзэж дураар нь тавих үзэл газар авчээ. Гэтэл биднээс хөгжлөөрөө 100 жилээр түрүүлсэн Япон эдийн засаг, худалдаагаа зохицуулж хэтийн төлөвлөгөөтэй хөгжүүлж байна. Хурдан хөгжиж хүчээ авсаар буй эдийн засаг, улс төр, гадаад бодлогоо маш нарийн төлөвлөж зохицуулсан аварга том лууны зөөлөн мөлхөө, ширвэлтэнд ядмаг эдийн засагтай, эмх замбараагүй, төрийн зохицуулалтаа бүрэн үгүйсгэж нээлттэй нийгэм, эдийн засгийн чиг баримжаагаар бүхнийг зөнд нь тавьсан, бас хэн ч, ямар ч буруу үйлдлийн төлөө хариуцлага хүлээдэггүй механизмтэй бид яаж тэсч үлдэх билээ.

БНХАУ ДХБ-д элсэхээр олон жил жөөцөлдөөд санасандаа хүрэв. Энэ нь Монголд яаж нөлөөлөх, эерэг, сөрөг үр дагаварын талаар бодлого боловсруулдаг байгууллага, судлаачид их анхаарч ажиллаж байгаа биз ээ.

Ямар эерэг нөлөө үзүүлэх вэ. Үүнд:

-ДХБ-ын үүрэг зорилтын үүднээс авч үзвэл аль аль талаасаа бараа бүтээгдэхүүний хориг багасч энэ нь үнийн өсөлтөд нөлөөлнө /үнэ буурна/.

Үүнтэй уялдаад бараа бүтээгдэхүүний сонголт ихсэх талтай. Манай улс импортын барааныхаа дийлэнх хувийг БНХАУ-аас авдаг. Манай импортын 60%, экспортын 15% нь ганц Хятадад ноогдож байна.

Хятадтай холбоотой элдэв маргааныг ДХБ-ын тусламжтай шийдвэрлэх боломжтой болох талтай.

Гэтэл сөрөг үр дагавар гарч ирэх нь зайлшгүй. Хятадын том зах зээл дэлхий дахинд улам нээлттэй болсноор манай экспорт, импортод нөлөөлнө. Манай зах зээл Хятадад улам бүр нээлттэй болно.

Хэрэг дээрээ манай хөдөө аж ахуйн түүхий эдийн үнэ, ноолуур арьс ширийн бэлтгэлийн үнэ Хятадуудын гарт ороод байна.

Үндэсний хөнгөн үйлдвэр (арьс шир, эсгий, эсгий гутлын, түүнчлэн хүнс тэжээлийн г.м) бас л тэдний гарт байна. Монголд ноолуурын 48 үйлдвэрийн тэн хагас нь Хятадын мэдэлд байна. 3000 тонн ноолуур бэлтгэж түүний 1/3 нь гаалийн татваргүй нууцаар урагшаа гардгийг төр засаг сайн мэдэж байгаа байх.

Эдийн засагчид, Дэлхийн банкныхны тооцоогоор Монгол улс өрийн дарамт ДНБ-ний нэг хүнд ногдох хэмжээгээр дэлхийн хамгийн ядуу орнуудын тоонд орж байна. Дунд зэргийн хөгжилтэй орнууд 20 орчим мянга, хөгжингүй орнуудынх (Скандинавын, Япон) 40 гаруй мянган доллар болж байгаа юм. Манай зарим эдийн засагч мөнхийн ядуу, сүйрлийн эрмэг дээр байгаа орон гэсэн дүгнэлт хийжээ.

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт жил бүр буурсаар ирсэн (1989 онд 4.2% бол эдүгээ 1% болтлоо буурчээ). Үнэтэй,

жинхэнэ байгалийн бүтээгдэхүүнээ Эрээн лүү зөөгөөд оронд нь өөртөө хямд эрээн мяраан юм авчраад байгааг шүүмжлэх аргагүй.

Тэгээд “зогсонги байдал хамаг доройтлоо шилжилт, эсвэл сэтгэлгээний хоцрогдол руу чихээд сууж байна. Яаж даяаршиж ямар ч ардчилсан эрх чөлөөтэй байлаа гэсэн улс үндэстний эрх ашиг, бодлого гэж байдаг. Хүн амын нь дийлэнх нь амьжиргааны доод түвшинд, ашиг орлого муутай өдөр шөнийг өнгөрөөж явна.

Хэвлэл уншиж радио сонсч суухад манайд ер нь болж бүтэж байгаа эдийн засаг, санхүү, банк, соёл, хууль эрх, эрүүлийг хамгаалах салбар байна уу гэж өөрийн эрхгүй бодогдоод байх боллоо.

Гадаадаас их зүйл сурч, гадаадынхны амыг нь харж байна. Энэ ч аргагүй биз ээ. Гэхдээ онол, арга зүйн, бодлогын чанартай шийдвэр гаргахдаа гол нь Монголынхоо нөхцлийг дэлхийн чиг хандлагатай уялдуулж байх нь чухал юм. Өрнөдийн зарим орны, тухайлбал АНУ-ын ХҮШ, XIX зууны хөгжлийн түвшинд ч хүрээгүй байна.

Зарим судлаач (Ч.Баатар) “Манайхан эдийн засгаа хэрхэн яаж сэргээх талаар бусдын туршлага судалдаг бол тэдний өнөөгийн ололтыг бус, тухайн улс гүрэн эдийн засгийн ноцтой уналт, бууралтад орсон үедээ түүнээс ямар арга зам, бодлогын хүчээр уг байдлаас гарч байсан туршлагыг судлах нь илүү үр өгөөжтэй гэж үзнэ” (Зууны мэдээ, 2001 он, X сарын 3). Энэ санааг би хувьд дэмждэг.

АНУ дэлхийн эдийн засгийн хямралын (1929-1933) үед байсан Ерөнхийлөгч Хувер сайн зохион байгуулагч байсан ч цаг үе нь аз завшаан авчраагүй гэж үздэг. Гэвч түүний засаглалын үед Хуверийн далан, усан цахилгаан станц, Теннесийн хөндийг хөгжүүлэх, ажилгүйчүүдийг ажилтай болгох томоохон хөтөлбөр боловсруулж түүн дээр нь Рузвельт тоглож амжилт олсон байдаг. Солонгосын дайны дараагийн зарим удирдагч 10-аад томоохон төслөөр өндийлгөсөн гэх юм билээ.

Даяаршил, интеграцчлал хоёр гүнзгий холбоотой нь мэдээж. Зүүн хойт Азийн зарим орнууд түүхэн хугацаанд янз бүрийн соёл иргэншил, уламжлал, шашин зэргийн уулзвар болж байсан. Энэ утгаараа Зүүн хойт Ази харь соёл, шашинтай харилцах туршлагын хувьд нэн баялаг юм. Монгол улс бол үүний нэг жишээ болох хандлагатай боллоо.

Монгол улс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа “Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн хойт Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг хангах, энх тайвныг бэхжүүлэх, аюулгүй байдлын найдвартай тогтолцоог бий болгох бодлого явуулах” гэж заасан билээ.

Зүүн хойт Азийн бүс нутагт эдийн засгийн интеграцчилах үйл явц хэдийгээр урсгал шинжтэй боловч сүүлийн жилүүдэд их идэвхжсэн байна. Эдийн засгийн бүсчлэл энэ бүс нутагт цаашид өрнөх улс төрийн хамтын ажиллагаа, аюулгүй байдлыг баталгаажуулахад их ач холбогдолтой бөгөөд өргөн утгаараа олон улсын ирээдүйн харилцаанд их үүрэгтэй юм. Зарим судалгаанаас үзвэл 2025 он гэхэд Япон, Хятад (дэлхийн хоёр, гурав дахь хамгийн том эдийн засаг), Солонгос (долоо эсвэл наймд орох) зэрэг улсууд Чөлөөт худалдааны бүсэд хамрагдвал 1.7 тэрбум хүн амтай, дэлхийн нийт бүтээгдэхүүний 35%, дэлхийн үйлдвэрлэлийн 45%-ийг эзлэх

бүс нутаг болно¹⁸. Тэгэхлээр энэ бүс нутаг бол Монгол улсын хувьд эдийн засаг, хөгжил, дэвшлийн нэгэн чухал нөхцөл болж байгаа. Түүгээр үл барам, энэ бүс нутагт даяаршлын үйл явдалд дулдуйдан ойртох, тэсч үлдэх гол арга зам болох магадлалтай юм.

Даяаршил улс орнуудын эдийн засаг, технологиор барахгүй соёл, боловсрол, ахуй, аюулгүй байдалд эерэг, сөрөг үр дагавар бүхий нийтлэг үзэгдлийн хувьд судлаачдын анхаарлыг үнэхээр татаж байна.

Даяаршил улс орнууд байр сууриа зөв тодорхойлж алсын хараатай идэвхтэй ажиллаж чадвал хөгжлийг түргэтгэх, нөөц боломжоо дайчилж дэлхийн зах зээлийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцлийг бүрэлдүүлэх, энх тайван тогтвортой байдалд нөлөөлөх, улс үндэстнүүдийн харилцан ойлголцох эерэг талыг нь бид ойлгож байна.

Даяаршлын ашигтай эерэг талууд, сөрөг үр дагаврыг аль аль талаас нь судалж ялангуяа Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах үүднээс алсын хараатай бодлого боловсруулж хэрэгжүүлэх. Үүний тулд:

-Гадаад бодлогодоо тунхагласан үзэл баримтлалын зэрэгцээ уян хатан дипломат ажиллагаагаар хангах;

-Улс үндэсний эрх ашгийг нам, улс төрийн хүчин, явцуу бүлэглэл, хувь хүний бизнесийн ашиг сонирхолд захируулахгүй гадаадад ч, дотоодод ч Төрийн нэгдсэн бодлого, нэгэн үзүүрт сэтгэлээр хандаж ажиллах;

-Үндэсний үйлдвэрлэл, хүн амын боловсролын систем, орон нутаг, эрүүл мэндээ өөд нь татах тоймтой цогц арга хэмжээ авах;

-Судалгаа, мэдээллийг төрийн бодлогодоо бүтээлчээр авч ашиглаж хэрэгжүүлэх. Жишээ нь манай хоёр том хөрш нэг нь ДХБ-д саяхан элсээд нөгөө нь элсэхээ азнаад байна. Үүний цаад учир шалтгааныг анхааран судлах.

-Манай улсын гадаад сурталчилгаа гэхэд л дан зуд, үхсэн малын сэг, эсвэл шүлхий өвчин, золбин хүүхэд, нохойгоо бус бас сайн сайхан зүйлээ зөв талаас нь харуулмаар байна;

-Даяаршлын эринд голлон тоглогч өндөр хөгжилтэй их гүрнүүдийн байр суурийг шууд хуулбарлан дууриах биш өөрийн орны онцлогийг харгалзан бүтээлчээр хандах, их далайн давалгаанд живэхгүй, залгигдахгүй тэсч үлдэх асуудалд анхаарах нь зүйтэй гэж үзнэ.

In his paper "The globalization and some aspects of natural interests and National Security of developing countries" the author considers that globalisation is not New Phenomenon. It is long-term process, intensified after Cold war era. Dr. Tsolmon made some comparative analyses of Scholars and politicians viewpoints regarding the globalization at present. He gives special attention to the opportunities and challenges of globalization for the small and developing countries, touching Mongolia's economic policies and National Security and some difficulties facing Mongolia today.

¹⁸ Short Report on Wilton Park Conference 628, North East Asia: Future Challenges, 12-16 February 2001

Ашигласан ном хэвлэл, өгүүлүүд:

1. Alison Brysk, Transnational Threats and Opportunities, Prepared for the conference on "Transnationalism," UCLA, May 5-8, 1999. "Globalization and Human Rights," project sponsored by UC Irvine's Global Peace and Conflict Studies.
2. Richard Little, International Relations and the Triumph of Capitalism, in Booth, K. & Smith, S. (eds) 1995: International Relations Theory, The Pennsylvania State University Press, pp62-89.
3. Sassen, S. 1991. The Informal Economy. In Dual City: Restructuring New York, ed. J.H. Mollenkopf and M. Castells, 79-99. New York: Russel Sage Foundation.
4. Lipschutz, R. 1996. Global Civil Society and Global Environmental Governance. New York: SUNY Press; Wapner, P. 1995. Politics Beyond the State Environmental Activism and World Politics. World Politics, 47 (3, April 1995): 311-40
5. John Gerard Ruggie, International Transformations: Essays on Institutional Change in the World Polity, Routledge, London, USA & Canada, 1998.
6. Bruce R. Scott, Incomes are diverging, Foreign Affairs, January/February 2001
7. John D. Steinbruner 2000: Principles of Global Security, The Brookings Institution.
8. Friedman, T. 2nd ed., Lexus and Olive Tree; understanding globalization, NY: Anchor Books. 2000
9. Stephen Noerper, Globalization and Integration, lecture given Autumn, 32000, SFS, MNU.
10. Short Report on Wilton Park Conference 628, North East Asia: Future Challenges, 12-16 February 2001.
11. Л.Н. Клепацкий, Глобализация и национальные интересы, Международная жизнь, № 1, 2000
12. Б. Батбаяр, Алтан гурвалжин, УБ, 2000
13. Е. Примаков, Россия и международные отношения в условиях глобализации. Международная жизнь, № 3, 2001
14. Д. Цолмон, Глобальчлал ба буурай орнуудын үндэсний эрх ашиг, "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын ШУ-ны үндэслэл" ЭШ-ний бага хурлын эмхэтгэл, УБ, 2001
15. Bayarkhuu D. "The Challenge of Globalisation and the Shaping of New World Order". Rajiv Gandhi Institute for Contemporary Studies. N.D. 2000
16. Г. Пүрэвбаатар "Монгол мөнхийн хоцрогдсон, мөнхийн ядуу орон байх ёсгүй". "Өнөөдөр", 2001.11.3
17. Country Reports on Economic Policy and Trade Practices. P.R. of China. 1998.